

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**Л. ХАЙСАНДАЙ. «МОНГОЛЬСКАЯ НАРОДНАЯ РЕСПУБЛИКА
И РАЗВИВАЮЩИЕСЯ СТРАНЫ (1955—1980)» УБ, 1982.**

Түүхийн шинжлэх ухааны дэд эрдэмтэн Л. Хайсандайн 1982 онд орос хэлээр хэвлүүлсэн «БНМАУ, хөгжиж байгаа орнууд (1955—1980)» (редактор-түүхийн шинжлэх ухааны доктор Ш. Сандаг) судалгааны бүтээл БНМАУ ба Ази, Африк, Латин Америкийн шинэ тулгар хөгжиж байгаа орнуудын хооронд улс төр, соёлын харилцаа тогтон өргөжиж, олон улсын тавцан дээр идэвхтэй хамтран ажиллаж байгаа 25 жилийн түүхэн замналыг нэгтгэн дүгнэжээ. Энэ хугацаанд уг бүтээл дотоод, гадаадын уишигчдын хүртээл болж түүний улс төр, эрдэм шинжилгээний ач холбогдлыг үнэлсэн зарим шүүмж ЗХУ, Польш зэрэг ах дүү орны хэвлэлд гарсан байна.

БНМАУ, хөгжиж байгаа орнуудын харилцааны сүүлийн 25 жилийн түүх, өөрөөр хэлбэл энэхүү харилцааны эхлэл, түүний шинэ үе шат-одоогийн шатны онцлогийг нээн харуулсан энэ ном гурван бүлэг, оршил, дүгнэлт бүхий бүтэцтэйгээр бичигджээ. Зохиогч БНМАУ, хөгжиж байгаа орнуудын хоорондын харилцааны хөгжлийн түүхийг гурван үе шат болгон хуваарилан авч үзсэн байна. Үүнд:

а. Нэгдүгээр бүлэгт- 1955—1959 оныг уг харилцааны хөгжлийн эхэн үе.

б. Хоёрдугаар бүлэгт. 1960—1969 оныг шинэ шат.

в. Гуравдугаар бүлэгт. 1970—1980 оныг өнөөгийн шат гэж үечлээд, үе тус бүрт уул харилцаа хэрхэн яаж хөгжиж ямар саад бартааг даван туулж, ямар ололт амжилтыг бататган бэхжүүлж ирсэн замналыг түүхчлэн харуулжээ.

Уг асуудлыг ингэж үечлэн авч үзсэн нь хронологийн дараалал баримтлах, үйл явдлаа эрэмбэ дараатай, цэгцтэй болгож, уншигч олонд ойлгомжтой болжээ.

Дэлхийн хоёрдугаар дайнд ЗХУ тэргүүтэй энхийг эрхэмлэгч хүчин ялж, империалист хүчин ихээхэн суларч доройтсоны дүнд дэлхийн тавцан дээр социализм үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн эрчимтэй өрнөх болсон билээ. Хүчний харьцааны ийм өөрчлөлтийн үрээр БНМАУ-ын олон улсын байр суурь бэхжиж, «Коломбын» болон Африк-Азийн орнуудтай найрамдлын харилцаа тогтоож эхэлсэн бөгөөд тэдгээр нь дайны эсрэг энх тайвны төлөө, улс түмний аюулгүй байдал, үндэсний тусгаар тогтнол, биеэ даасан байдлыг хангахын төлөө хамтран тэмцсэн үеийг 1955—1959 оны хүрээнд хамруулан авч үзээд энэ үеийг уг харилцааны хөгжлийн эхэн үе гэж тодорхойлсон байна.

БНМАУ-ын олон улсын нэр хүнд улам өсөж үндэсний биеэ даасан улсуудтай түүний харилцаа улам өргөжиж шинэ шинэ хэлбэр онцлогтой болж ирсэн 1960—1969 оныг энэхүү харилцааны хөгжлийн шинэ үе шат болгон харуулжээ.

Төгсгөлийн бүлэгт: БНМАУ Азийн энх тайван аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс хөгжиж буй орнуудтай нөхөрлөл найрамдлын холбоо харилцаагаа бэхжүүлж, сүүлийн жилүүдэд олон улсын тулгамдсан асуудлуудыг нааштай шийдвэрлэхэд БНМАУ ба хөгжиж буй орнуудын хамтын ажиллагаа идэвхжиж буй 1970—1980 оныг уг харилцааны өнөөгийн үе шат болгон харуулсан байна.

Чөлөөлөгдсөн орнуудтай тогтоосон манай нөхөрсөг хэлхээ холбоо нь эдүгээ зөвхөн дипломат харилцаагаар зогсохгүй нам, төр, засгийн болон олон нийт, урлаг соёлын төлөөлөгчид харилцан солилцох, кино үзэсгэлэн гаргах, ном хэвлэл солилцохоос эхлээд улс түмний энх тайван, аюулгүй байдлыг хангаж бэхжүүлэх асуудлаар НҮБ болон олон улсын бусад байгууллагад БНМАУ, шинэ тулгар хөгжиж байгаа орнууд идэвхтэй хамтран ажиллаж байгааг зохиогч онцлон тэмдэглэжээ. (73—78, 82—84-р тал)

НҮБ, түүний салбар байгууллагууд БНМАУ-ын санаачлагаар тухайлбал, хөгжиж байгаа орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжилд улсын секторын үүрэг, мэргэжилтэй боловсон хүчний гүйцэтгэх үүрэг, бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах талаар бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлэх тухай, эмэгтэйчүүдээс ардын боловсролын салбарт гүйцэтгэх үүргийг дэвшлүүлэх тухай, эдийн засаг, техникийн талаар хамтран ажиллах нөхцөл болзлын тухай, нийгмийн дэвшлийн үүднээс нийгэм-эдийн засгийн гүнзгий өөрчлөлт хийх тухай, хоршооллын хөдөлгөөнийг дэмжих үндэсний туршлагын тухай зэрэг хэд хэдэн чухал тогтоол зөвлөмж баталж гаргасны ач холбогдлыг зохиогч иш үндэстэй нотолсон байна. (85—86-р тал)

Зохиогч БНМАУ ах дүү бусад орны хамт бүрэн тэгш эрхтэй байх, бие биесийн дотоод хэрэгт үл оролцох, харилцан ашигтай байдалд тулгуурласан олон улсын эдийн засгийн шинэ харилцаа тогтоохын төлөө хөгжиж байгаа орнуудын тэмцлийг гуйвалтгүй дэмжиж байдгийг цохон тэмдэглээд «ЗХУ болон социалист нөхөрлөлийн бусад улстай БНМАУ-ын тогтоон хөгжүүлж байгаа жинхэнэ тэгш эрх, ах дүү ёсны харилцаа, хамтын ажиллагаа нь чөлөөлөгдсөн орны ард түмэнд мөлжлөг хараат байдлыг арилгах эдийн засгийн шинэ журмын төлөө тэмцэхэд нь үнэн зөв баримжаа олгож чадна» гэсэн дүгнэлт хийжээ. (91 дэх тал)

Зохиогч номдоо БНМАУ, социалист чиг баримжаат орнуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагаа улам ойр дотно, тал бүрийг хамран агуулга хэлбэрийн хувьд улам баяжиж хөгжих сайхан хэтийн төлөв бий болсон явдал бол эдгээр орнуудад БНМАУ-ын капиталист биш хөгжлийн туршлага онцгой чухал ач холбогдолтой болж байгаа хүчин зүйл гэдгийг БНМАУ болон социалист чиг баримжаат орнуудын нам төрийн удирдагчдын хэлсэн үг, баримт бичиг, бусад олон жишээ баримтаар нотолжээ. (80—81 дэх тал)

Зохиогч БНМАУ ба чөлөөлөгдсөн орнуудын харилцаа, хамтын ажиллагаа социализмын ба үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нийтлэг язгуур эрх ашигт тулгуурлан амжилттай хөгжиж бэхжиж байгааг тэмдэглээд энэ нь **нэгдүгээрт**: МАХН-ынхаа мэргэн удирдлагын дор гуйвалтгүй явуулж буй манай улсын энх тайван, найрамдлыг эрхэмлэсэн гадаад бодлогын нэгэн чухал үр дүн, ололт **хоёрдугаарт**: Манай орны болон нийт социалист нөхөрлөлийн нэр хүнд, байр суурь олон улсын тавцан дээр хэлбэрэлтгүй өсөн бэхжиж буйн бодит биелэл; **гуравдугаарт**: чөлөөлөгдсөн орнууд орчин үеийн олон улсын үйл амьдрал, Лениний хэлсэнчлэн бүх дэлхийн хувь заяаг шийдвэрлэхэд улам бүр идэвхтэй оролцож чухал үүрэг гүйцэтгэх болсны нэг тод илрэл; **дөрөв-**

дүгээрт: Улс түмний аюулгүй байдал, харилцан ойлгох явдлыг ханган биелүүлэх, олон улсын харилцааг ардчилан өөрчлөх үйлсэд оруулж буй зохих хувь нэмэр мөн гэсэн гол гол дүгнэлт хийснээс гадна бодит социализмын орнууд ба хөгжиж байгаа орнуудын хоорондын харилцааны талаархи хөрөнгөтний болон зүсэн зүйлийн оппортунист, маоист үзэл номлолыг зохих ёсоор шүүмжлэн няцаалт өгсөн байна.

БНМАУ, хөгжиж байгаа орнуудын харилцааны асуудалд зориулсан Л. Хайсандайн судалгааны энэ ном мэргэжлийн хүмүүс болон өргөн олон уншигчдад МАХН-ын гадаад улс төрийн бодлого БНМАУ-ын гадаад харилцааны түүхийг судлах чухал хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй.

Ц. Баатар